



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын сумын Засаг даргын тамгын газрын
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/102/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2024 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2495 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580

E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 220

танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ДАРГА Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр улсын тэргүүний Хутаг-Өндөр сумаас Улсын аврага тариаланч хамт олон 2, улсын аврага тариаланч 1 тодорсон байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд сумын Засаг даргын 2023 оны А/381 тоот захирамжаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 537,109.9 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тайланд бүртгэж, санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлогоор тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

006020509

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

		(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт		2022.12.31.	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	114,201.9	121,454.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,831,965.9	3,125,971.6
	Нийт хөрөнгийн дүн	2,946,167.8	3,247,425.7
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,943,242.0	3,243,923.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,946,167.8	3,247,425.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,173,294.3	1,715,089.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	849,479.1	1,412,701.1
	Үйл ажиллагааны үр дүн	323,815.2	302,388.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	(49,500.0)	(1,707.2)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	274,315.2	300,681.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,668,926.9	2,943,242.0
	Тайлант оны үр дүн	274,315.10	300,681.50
	Эцсийн үлдэгдэл	2,943,242.0	3,243,923.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	779,947.4	1,013,704.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	567,569.9	913,406.6
	Үйл ажиллагааны ЦМГ	212,377.5	100,297.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(212,377.5)	(100,297.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	842,734.9
	Урсгал зардал	-	822,734.9
	Хөрөнгийн зардал	-	20,000.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	842,734.9
	Улсын төсвөөс санхүүжих	-	833,264.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	9,470.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3,770,931.3 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,770,931.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Төсвийн шууд захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 24-ны 01/29 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүрэлдэхүүн, иж бүрдлийг хангаж ирүүлээгүй,
- Үндсэн хөрөнгийн тайланд шилжүүлэн авсан үндсэн хөрөнгийг худалдан авсан үндсэн хөрөнгөөр тайлагнасан нийт 3,770,931.3 мянган төгрөгийн алдааг УСНББОУС 1- Санхүүгийн тайлангийн толилуулга, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар"-ын дагуу залрууллаа.

Аудитаар нийт 12,605.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,614.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 8,991.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1 албан шаардлага, 1 зөвлөмжийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 136.6 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс цэрэг эх оронч үзэл олгох бүхий "Бидний бахархал" сэдэвт арга хэмжээний анхан шатны баримт дутуу, албан томилолтоор ажиллаж байгаа хүмүүст хоол хүнс, буудал байрны зардал давхардуулан, үр ашиггүй, зориулалт бус зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 7.1 дэх заалт эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 3,614.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тушаал шийдвэргүйгээр 8,991.4 мянган төгрөгийн албан томилолтыг зарцуулсан нь Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох тухай” журам, НББ-ын тухай хуулийн 4 дүгээр зүйл, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтоор ажиллах тухай бүрд шийдвэр гаргаж, НББ-ийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажил гүйлгээг хийж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)												
Алдааны товч утга	Нийт алдаа		НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн шууд захирагчийн 2024 оны 01 дүгээр сарын 25-ны 03/77 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан бүрэлдэхүүн, иж бүрдлийг хангаж ирүүлээгүй.	1	3,240,043.9	1	3,240,043.9			1	3,240,043.9				
Үндсэн хөрөнгийн тайланд шилжүүлэн авсан үндсэн хөрөнгийг худалдан авсан үндсэн хөрөнгөөр тайлагнасан.	1	530,887.4	1	530,887.4			1	530,887.4				
Дүн	2	3,770,931.3	2	3,770,931.3			2	3,770,931.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)												
Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын нөөц хөрөнгөөс цэрэг эх оронч үзэл олгох бүхий "Бидний бахарал" сэдэвт арга хэмжээний анхан шатны баримт дутуу, албан томилолтоор	1	3,614.3			1	3,614.3						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Хутаг-Өндөр сумын ЗДТГ	1	1			1			
	ТШЗ-ийн дүн	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1			1			